



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/78.

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах шатрын насанд хүрэгчдийн блиц тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах шатрын насанд хүрэгчдийн блиц тэмцээнийг 2016 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.470.000 /нэг сая дөрвөн зуун далан мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Э.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

115050014

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2016 оны сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
шатрын насанд хүрэгчдийн блиц тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 6 x 40.000 төг = 240.000 төг 6 x 30.000 төг = 180.000 төг 6 x 20.000 төг = 120.000 төг	540.000
2.	Шүүгчдийн мөнгө: /8 хүн x 2 өдөр x 20.000 төг= 320.000 төг	320.000
3.	Диплом, өргөмжлөл 70ш x 2000=140.000	140.000
4.	Медаль 29 x 10.000 = 290.000	290.000
5.	Цом 6 x 30.000 = 180.000	180.000
ДҮН:		1.470.000

Боловсруулсан:
Хянасан:

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2016 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн
..... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах шатрын
насанд хүрэгчдийн блиц тэмцээний
шүүгчдийн бүрэлдхүүн

- | | |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | Ж.Лхагва |
| 2. Нарийн бичиг шүүгч | Ж.Ган-Од |
| 3. Шүүгч | П.Бадрал |
| 4. шүүгч | П.Жигжидсүрэн |
| 5. Шүүгч | Г.Оюунчимэг |
| 6. Шүүгч | С.Цогт-Очир |
| 7. Шүүгч | А.Баярсайхан |
| 8. Шүүгч | А.Пүрэвжав |